



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Арвайхээр сум

**Цэргийн бүртгэл явуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4, 34 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны цэргийн бүртгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 05-наас 01 дүгээр сарын 19-ний өдрийг хүртэлх хугацаанд бүх сумдад биечлэн болон цахим хэлбэрээр зохион байгуулсугай.

2.Цэргийн бүртгэл явуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинээр байгуулж, бэлтгэл ажлыг ханган зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3.Иргэдэд 2024 оны цэргийн бүртгэлийг цахим хэлбэрээр бүртгэх талаарх мэдээлэл зөвлөгөө өгөх, 19 суманд цахим операторын горимоор үйлчилгээ үзүүлэх ажлыг Өвөрхангай аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс (Н.Ширчин)-т даалгасугай.

4.Цэргийн бүртгэлийн үед цэргийн штабын офицеруудын зарим сумдад ажиллах хуваарийг 1 дүгээр, шаардагдах төсвийг 2 дугаар, цэргийн бүртгэлийн тайлан мэдээ, судалгааг хүлээн авах хуваарийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

5.Цэргийн бүртгэлийн үйл ажиллагаанд зарцуулах 1,358,000 (нэг сая гурван зуун тавин найман мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд )-т зөвшөөрсүгэй.

6.Цэргийн бүртгэлийг үнэн зөв явуулахад мэргэжлийн удирдлага, туслалцаа үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж, тогтоосон хугацаанд тайлан мэдээг нэгтгэж, Зэвсэгт хүчний Жанжин штабын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газарт хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб (дэд хурандаа А.Нямхүү)-т үүрэг болгосугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

**6224 11 0001**

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 01-ны өдрийн 101 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



ЦЭРГИЙН БҮРТГЭЛИЙН ҮЕД ЦЭРГИЙН ШТАБЫН  
ОФИЦЕРУУДЫН СУМДАД АЖИЛЛАХ ХУВААРЬ

№	Сумдын нэр	Он.сар.өдөр	Явах бүрэлдэхүүн
1	Нарийнтээл	2024.01.08	Дэд хурандаа А.Нямхүү Хошууч Т.Батсайхан
2	Хайрхандулаан	2024.01.08	
3	Тарагт	2024.01.08	
4	Бат-Өлзий	2024. 01.09	Дэд хурандаа Ч.Адъяа
5	Арвайхээр	2024.01.09	Дэд хурандаа А.Нямхүү Дэд хурандаа Ч.Ванчинсүрэн
6	Зүүнбаян-Улаан	2024.01.10	
7	Хужирт сум	2024.01.10	
8	Хархорин сум	2024.01.11	

-оОо-

Аймгийн Засаг даргын 2024 оны ... дугаар сарын...-ны өдрийн ... дүгээр захирамжийн 2 дугаар хавсралт

2024 ОНЫ ЦЭРГИЙН ТОО БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ТӨСӨВ

1. Шатах тослох материалын тооцоо

№	Зориулалт	Машин		Шаардагдах ШТМ		Нэгжийн үнэ		Бүгд үнэ		Нийт үнэ	
		марк	тоо	явах км	А-92 (л)	Масло (л)	А-92 (л)	Масло (л)	А-92 (л)		Масло (л)
1	Цэргийн ажлаар 6 бүртгэлийн суманд ажиллах	Ланд-105	1	1000	200	1	2470	-	494,000	-	494,000
	Дүн		1	1000	200	1	2470	-	494,000	-	494,000

2. Хоолны төсөв

Д/д	Зориулалт	Хүний тоо	Хэдэн удаа	Нийт хүн	Үнэ	Нийт үнэ
1	Цэргийн бүртгэлийн дүн мэдээг хүлээлгэн өгөх сумдын ЗДТГ-ын хоолны зардал	38	2	72	12000	864,000
4	Дүн	38	2	72	12,000	864,000
	Нийт дүн					1,358,000

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр  
сарын 02-ны өдрийн 101 дугаар  
захирамжийн 3 дугаар хавсралт



СУМДЫН ЦЭРГИЙН БҮРТГЭЛИЙН МАТЕРИАЛЫГ  
ХҮЛЭЭН АВАХ ХУВААРЬ

№	Сумдын нэр	Он, сар, өдөр	Хугацаа
1	ЗБУ	2024.01.25	09.00-13.00
2	Тарагт	2024.01.25	14.00-18.00
3	Нарийнтээл	2024.01.26	09.00-13.00
4	Хайрхандулаан	2024.01.26	14.00-18.00
5	Баянгол	2024.01.29	09.00-13.00
6	Төгрөг	2024.01.29	14.00-18.00
7	Баруунбаян-Улаан	2024.01.30	09.00-13.00
8	Сант	2024.01.30	14.00-18.00
9	Баян-Өндөр	2024.01.31	09.00-13.00
10	Өлзийт	2024.01.31	14.00-18.00
11	Бүрд	2024.02.01	09.00-13.00
12	Гучин-Ус	2024.02.01	14.00-18.00
13	Есөнзүйл	2024.02.02	09.00-13.00
14	Хужирт	2024.02.02	14.00-18.00
15	Уянга	2024.02.05	09.00-18.00
16	Бат-Өлзий	2024.02.06	09.00-18.00
17	Хархорин	2024.02.07	09.00-18.00
18	Богд	2024.02.15-16	09.00-18.00
19	Арвайхээр	2024.02.19-20	09.00-18.00

-оОо-